

# Хэрвээ та гадаадад вакцинд хамрагдсан бол КОВИД-19-н вакцинжуулалтаа хэрхэн батлан харуулах тухай

Хэрвээ та 2020 оны 10-р сарын 1-ний өдөр эсвэл түүнээс хойш гадаадад байх хугацаандаа хүлээн зөвшөөрөгдсөн вакцинжуулалтанд хамрагдсан бөгөөд Австрали улсын хилээр нэвтрэхдээ **Австрали улсад Зорчих Мэдүүлэг** бөглөн шалгуулсан бол та уг мэдүүлгийг КОВИД-19-н халдварын эсрэг вакцинжуулалтын баталгаа болгон харуулж болно. Мөн та доор дурдсан алхмуудын дагуу Австралийн Дархлаажуулалтын Бүртгэлд (AIR) өөрийн вакцинжуулалтаа бүртгүүлэн **КОВИД-19 дижитал сертификат** эсвэл **дархлаажуулалтын түүх бүхий батламж** авснаар КОВИД-19 халдварын эсрэг вакцинжуулалтаа нотлох боломжтой болно.

- 1 Гадаадад хамрагдсан таны вакцин Австралид хүлээн зөвшөөрөгдсөн эсэхийг шалгана уу (одоогоор Pfizer, AstraZeneca Vaxzevria, Moderna, Janssen-Cilag, Sinovac Coronavac, AstraZeneca Covishield, Sinopharm болон Bharat Biotech хүлээн зөвшөөрөгдөж байна).
- 2 Хэрвээ таны вакцинжуулалтын бүртгэл өөр хэл дээр бичигдсэн бол Англи хэл рүү орчуулна уу. Орчуулгын Үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдах боломжтой эсэхээ [translating.homeaffairs.gov.au](http://translating.homeaffairs.gov.au) вэб хуудсаар зочлон шалгана уу.
- 3 Та өөрийн вакцинжуулалтаа хүлээн зөвшөөрөгдсөн, вакцинжуулалт хийх эрх бүхий ажилтнаар (өрхийн эмч (GP) эсвэл эм зүйч гэх мэт) AIR-д бүртгүүлнэ үү. Ингэснээр уг вакцинжуулалт таны КОВИД-19 дижитал сертификат эсвэл дархлаажуулалтын түүх бүхий батламж дээр харагдах болно.
- 4 Та өөрийн сертификат эсвэл батламжаа доорх аргуудын аль нэгийг ашиглан харах боломжтой:

myGov дээрх таны цахим Medicare аккаунт	Express Plus Medicare гэсэн мобайл апп	Individual Healthcare Identifiers үйлчилгээ (хэрвээ танд Medicare байхгүй бол)
<ol style="list-style-type: none"> <li>1. <a href="http://my.gov.au">my.gov.au</a> руу орж, нэвтрэнэ.</li> <li>2. <b>Proof of COVID-19 vaccination</b> гэсэн шуурхай холбоос дээр дарна.</li> <li>3. <b>View history</b> гэдгийг сонгоно.</li> <li>4. <b>Нэрээ</b> сонгон, <b>View immunisation history statement</b> эсвэл <b>View COVID-19 digital certificate</b> харах гэдгийг сонгоно.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. <b>Express Plus Medicare</b> апп-аар нэвтэрч орно.</li> <li>2. Үйлчилгээнүүд дотроос <b>Proof of vaccinations</b> гэдгийг сонгоно.</li> <li>3. <b>View history</b> гэдгийг сонгоно.</li> <li>4. Өөрийн <b>нэрээ</b> сонгоно.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. <a href="http://my.gov.au">my.gov.au</a> руу орж, нэвтрэнэ.</li> <li>2. <b>Individual Healthcare Identifiers service</b> гэдгийг сонгоно.</li> <li>3. <b>Immunisation history</b> гэдгийг сонгоно.</li> </ol>

Тэмдэглэл: Хэрвээ та Medicare авах боломжгүй мөн цахимаар КОВИД-19 вакцинжуулалтын баталгаа авах хэрэгтэй бол Individual Healthcare Identifier (IHI) гэсэн дугаар авах шаардлагатай. Та myGov-р энэхүү IHI дугаарыг авах боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг [servicesaustralia.gov.au/covidvaccineproof](http://servicesaustralia.gov.au/covidvaccineproof) вэб хуудсаар орж авна уу.

- 5 КОВИД-19 вакцинжуулалтын баримтаа хадгалж аваарай. Та өөрийн сертификатаа Apple Wallet эсвэл Google Pay дээрээ нэмэх, эсвэл Express Plus Medicare мобайл апп дээрээ хадгалж болно.

Мөн вакцинжуулалтын баталгаагаа Service NSW апп дээр нэмснээр та аливаа байгууллага, газруудад орохдоо баталгаагаа харуулахад түргэн бөгөөд хялбар байх болно. Үүнийг хэрхэн хийх тухай зааврыг [nsw.gov.au/covidvaccineproof](http://nsw.gov.au/covidvaccineproof) вэб хуудаснаас авна уу.

Эсвэл та сертификат эсвэл батламжаа гэртээ хэвлэж болно. Та myGov дээрх Medicare цахим аккаунтаараа эсвэл Express Plus Medicare апп дээрээ PDF хувилбараар татаж авч, хэвлэн биедээ авч явж болно. Хар цагаан өнгөгүй хуулбар хүлээн зөвшөөрөгдөх болно.

Хэрвээ та эрүүл мэндийн эсрэг заалтаар (энэ нь та ямар нэгэн эрүүл мэндийн шалтгаанаар КОВИД-19 вакцинжуулалтанд хамрагдах боломжгүй гэсэн үг) КОВИД-19-н вакцинжуулалтанд хамрагдах боломжгүй бол эмчээсээ тухайн эсрэг заалтыг AIR дээр бүртгэж өгөхийг хүсээрэй. Ингэснээр энэ нь таны сертификат болон мэдэгдэх хуудас дээр харагдах болно.